

Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын
22-ны өдрийн А/39 дүгээр тушаалын
12 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ



I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Хот байгуулалт, хотын стандартын
газар

Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн
төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Замын хөдөлгөөн, төлөвлөлт
хариуцсан инженер

ТУ-7

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын
зам 1200, Нийслэлийн Нутгийн Захиргааны
цогцолбор барилга

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад
хууль тогтоомж, шийдвэр, сандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангах, нийслэл хотын
авто замын хөдөлгөөний эрчмийг тооцоолох, авто замын сүлжээг оновчтой төлөвлөж
авто замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлж
гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хууль тогтоомж, стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангах, тайлагнах.
- 2.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэлийн авто замын хөдөлгөөн зохион байгуулалтын тооцоо, судалгаа хийх, инженерчлэлийн түвшинд төлөвлөх, төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоо боловсруулах, улс, нийслэлийн төсөвт тусгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах.
- 3.Нийслэлийн авто замын хөдөлгөөний ачааллыг тооцоолох, авто замын хөдөлгөөний зохицуулалтыг боловсронгуй болгох, төсөл хөтөлбөрийг холбогдох хууль дүрэм, журамд нийцүүлэн санаачлан боловсруулах, төлөвлөлтийн шийдэл, төсөл хөтөлбөрийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгах, хэрэгжилтийг хангаж ажиллах.
- 4.Авто зам, замын байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах, зогсоол хийх, инженерийн шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажилтай холбогдуулан зураг төсөлд санал өгөх, ажлын зураг төсөл зөвшилцөх.
- 5.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын урт хугацааны болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлд тусгагдсан нийслэлийн авто замын төлөвлөлтийн арга хэмжээг холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах;	Авто замын тухай хууль, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг нийцүүлэн уялдуулж ажилласан байна.	Г, Т
	2.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон ХЕТ-ний авто замын сүлжээний төлөвлөлтийг хэрэгжүүлэх;	Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн гудамж замын сүлжээний хүчин чадал нэмэгдүүлсэн байна.	Г, Т
	3.Нийслэл хотын гудамж замын сүлжээний төлөвлөлт, Нутаг дэвсгэрийн ХЕТ-ний төсөлд санал өгөх, мэргэжлийн арга зүй, мэдээллээр хангах;	Холбогдох норм ба дүрэм, Олон улсын стандартад нийцсэн гудамж замын төлөвлөлтийг батлуулсан байдлаар	Г, Т
	4.Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай болон бусад хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд санал оруулах, салбарын норм дүрэм, стандартад санал өгөх, хэрэгжүүлж ажиллах;	Норм норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох ажилд санал өгсөн байна.	Г, Т

2 дугаар зорилтын хүрээнд	1.Нийслэлийн авто замын сүлжээ, авто замын хүртээмж, эрчимийн судалгаа, урьдчилсан тооцоо боловсруулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээг нэмэгдүүлэх, хөгжүүлэх болон сайжруулах шаардлагатай байршлуудын санал боловсруулах;	Иргэд олон нийтээс ирсэн санал болон судалгаа шинжилгээнд тулгуурлан шинээр барих, өргөтгөн шинэчлэх, засварлах, дахин төлөвлөх шаардлагатай авто зам, замын байгууламж, явган болон дугуйн замын трассыг хооронд нь уялдуулан цогцоор төлөвлөх.	Г, Т
	2.Замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах, шаардлагатай байршилд хөдөлгөөний эрчимийн тооцоолол, дүн шинжилгээ хийж, үр ашгийг тооцоолох, шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо боловсруулах, санал өгөх;	Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэнтэй хамтран төлөвлөсөн трассуудад дүн шинжилгээ хийж тээврийн эрэлт, эдийн засгийн үр өгөөжийг тооцоолох, уулзвар, гол зам, туслах замуудын нэвтрэх чадварыг сайжруулах тооцоог гаргах, гудамж замуудын нэвтрэх чадварын эрэмбийг тогтоосон байна.	Г, Т
	3.Авто замын ажлын зураг төсөлд урьдчилсан хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөлтийг хийж, зураг төсөл боловсруулах ажилд санал өгөх, бусад инженерүүдтэй зөвшилцөх мэдээллээр хангах;	Төлөвлөсөн трассуудтай огтлолцож буй гудамж зам болон хэрэгжиж буй бусад төсөл арга хэмжээнүүдтэй уялдуулан тухайн замын нэвтрүүлэх чадвар, уулзвар, орц гарцын урьдчилсан төлөвлөлтийг гүйцэтгэх, техникийн шийдлийн дагуу боловсруулж буй зураг төслийн ажилд санал өгөх, зөвшилцөх.	Г
	4.Зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, санал өгөх, хэрэгжилтийг хангуулах;	Судалгаа шинжилгээ болон ТЭЗҮ боловсруулах ажлын явцад хяналт тавьж, холбогдох актаар хүлээн авах.	Г

3 дугаар зорилтын хүрээнд	1.Газрын дүрэм, дотоод журам болон бусад дүрэм журмыг судалж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;	Хууль эрх зүйн акт, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байна.	Г
	2.Байгууллагын инженер техникийн ажилтнууд болон иргэд, аж ахуйн нэгжийг авто замын талаарх мэдээллээр хангаж ажиллах;	Холбогдох мэдээллээр хангасан байна.	Г
	3.Авто замын хөдөлгөөний ачааллыг тооцоолж, гудамж замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх тухай тооцоо, судалгаа хийх, авто замын хөдөлгөөний зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр олон улсад хэрэгжиж буй арга хэмжээг тусгах, төсөл хөтөлбөрийг холбогдох хууль дүрэм, журамд нийцүүлэн санаачлан боловсруулах, хот байгуулалтын мэдээллийн менежементийн системд баяжилт хийж ажиллах.	Холбогдох журам, дүрэм хуульд санал өгөх, боловсруулах, байгууллагыг холбогдох мэдээллээр хангах,Хот байгуулалтын мэдээллийн санд төлөвлөж буй шугамын төлөвлөлтийн шийдэл болон зөвшилцсөн ажлын зураг төслийн шугамын мэдээлэл орсон байна.	Г,Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Авто зам, замын байгууламжийг сэтлэх сүвлэх, орц, гарц гаргах, зогсоол хийх ажилд санал өгөх зөвшилцөх, хөдөлгөөн зохион байгуулалтын саналыг өгөх;	Холбогдох зөвшөөрөл, санал өгөх, хамтрагч байгууллагуудтай зөвшилцөх, зохион байгуулж буй хурал зөвлөгөөнд байгууллагыг төлөөлж санал өгөх, шийдэл гаргах	Г
	2. Авто замтай огтлолцож буй дэд бүтцийн шугам сүлжээний зураг төсөлтэй зөвшилцөж, санал зөвлөмж өгөх.	Шинээр болон дахин төлөвлөлт хийж буй хаяа дагуул хот, хороолуудын авто замтай дагуу болон хөндлөн чиглэлд огтлолцож буй хэсгийн техникийн шийдэлд санал өгч, зөвшилцөн ажиллах.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан байна.	Г
	2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон	Эрх бүхий албан тушаалтанд ХАСХОМ-ийг өгсөн ашиг байдал,	Г

	Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;	сонирхлын зөрчлөөс ангид байна.	
	3.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байх.	Г
	4.Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур чадвараа тогтмол дээшлүүлэх.	Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур чадвараа тогтмол дээшлүүлэн ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- авто замын инженерчлэл /073210/; - гүүрийн инженерчлэл /073205/; - хөдөлгөөн зохион байгуулалтын инженер;		
Мэргэшил	Харгалзахгүй		
Туршлага	Харгалзахгүй		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн шинжилгээ хийх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж, боловсруулах; - шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг боловсруулах; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эрсдэлийг тооцох, хариуцах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах; - албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх;	

		- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - бусад.
	Бусад	- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай байх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;
- төрийн болон төрийн бус байгууллага;
- иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

..... (Д.ДАШЦЭЦЭГ)
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 07 дугаар сарын 22 ны өдөр

Албан тушаал
ДАРГА
(тамга/тэмдэг)

..... (Г.БАТЗОРИГ)
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 07 дугаар сарын 22 ны өдөр